

эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгоход анхаарлаа хандуулсаар ирсэн юм.

Эдгээр эрх зүйн баримт бичгүүдийг судлан дүн шинжилгээ хийхэд манай улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, улсын хилтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг сайжруулах, боловсронгуй болгоход ашигтаж болох шинэлэг санаа, туршлагууд байгаа талаар санал, зөвлөмж дэвшүүлэх боломжтой байна.

*П.Эрдэнэбаяр-ХСИС, Хууль сахиулахын
удирдлагын акадамын 8042 дугаар
дамжааны суралцагч, дэд хурандаа*

*Я.Ариунболд-Хууль сахиулахын удирдлагын
акадамын Хилийн албаны удирдлага, стратегийн
профессорын багийн профессор, хурандаа*

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ҮНДСЭН ЗАРЧИМ БА УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Хураангуй. Улсын хил хамгаалалтын зарчим нь хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрмээр баталгаажсан байна, харин улсын хил хамгаалалтад тавигдах шаардлага огт тусгагдаагүй байна. Иймээс улсын хил хамгаалалтад тавигдах шаардлагын талаар тусгайлан судлах нь зүйтэй гэж үзэж, хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрэмд хилийн отряд болон хилийн заставын улсын хил хамгаалалтад тавигдах үндсэн зарчим, шаардлагуудыг хэрхэн тусгаж байсан, өөрчлөгдсөн байдал, түүний хэрэгжилтийн талаар болон хөрш орнуудын хил хамгаалалтад тавигдаж буй зарчим, шаардлагын талаар харьцуулаи судлаж үзлээ.

Түлхүүр үг. Хилийн нэр томъёоны тайлбар тольд:

“Зарчим” гэж 1. Ямар нэгэн онол, сургаал, шинжлэх ухаан, ертөнцийг үзэх үзэл, улс төрийн зохион байгуулалтын үндсэн эх баримтлал, 2. Бодит байдалд хүний хандах хандлага, зан төлөв, үйл ажиллагааны хэм хэмжээг тодорхойлж буй итгэл үнэмшил, 3. Аливаа механизм, багажийн зохиомжийн гол онцлог,

“Улсын хил хамгаалалтад тавигдах шаардлага” гэж улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах зорилгоор хил хамгаалах удирдамж, тушаал, хоногийн төлөвлөгөөний дагуу зайлшгүй хийгдэх арга хэмжээнүүд. Улсын хилийг тасралтгүй хамгаалах, хил хамгаалалтыг гүнтэйгээр зохион

байгуулах, онцлог чиглэлд үндсэн хүч хэрэгслийг хуралдуулах зэргээс бүрдэнэ"¹ гэж онолын хувьд тайлбарласан.

Харин хилч эрдэмтэн доктор, хурандаа Н.Наранжамц өөрийн “Улсын хил хамгаалалтын практик асуудлууд” хэмээх бүтээлдээ:

Улсын хил хамгаалах үйл ажиллагааны зарчимууд нь амжилт олоход чухал хэрэгцээтэй бүтэц түүний бүрдлүүдийг чанарын үндсэн түвшинг илэрхийлсэн. томоохон олон талт үйл ажиллагааг гүйцэтгэхэд зайлшгүй дагаж мөрдөх баримтлалууд байх ёстой. Эдгээр онолын зарчимууд нь улсын хил хамгаалалтын үйл явцын хууль, зүйн тогтлыг танин мэдсэний үндсэн дээр боловсруулагдана. Хил хамгаалах албаны практикт, энэхүү үзэгдлийн тогтвортой холбоосын хууль, зүйн тогтлыг хэрэглэх нь үндсэн баримтлал болдог.

Зарчим гэдэг нь улсын хил хамгаалах явцад эсрэг тал (дайсан)-тай тэмцэхэд амжилт олох нөхцлийг бүрдүүлэгч, өөрийн хүч хэрэгслийн өөр хоорондоо нягт холбоо бүхий байнга давтагдаж байдаг, хүмүүсийн оюун санаанд тусгалаа олсон иж бүрэн үйл ажиллагаа юм. Эдгээр нь онол, практикийн холбоос болдог ба түүний үнэн зөв эсэх нь улсын хил хамгаалах үйл явцын олон талт үзэгдлүүдийн гүнд хир зэрэг нэвтэрснээс шалтгаална.

Улсын хил хамгаалалт нь нийгэм-улс төрийн хүнд төвөгтэй үйл явц учраас түүнийг зөвхөн онолын хувьд судалдаггүй, харин цэргийн болон хил судлалын шинжлэх ухаан, улсын аюулгүй байдлыг хангах онол, нийгэм-улс төр, байгаль, экологийн шинжлэх ухааны тусгай салбаруудаар давхар судалж байдаг. Ийм учраас улсын хил хамгаалах онол нь цэргийн шинжлэх ухаан, улсын аюулгүй байдлыг хангах онолын салбаруудтай нягт холбоотой байдаг нь зүй ёсны бөгөөд тэдгээрийн зарим ойлголт, үг хэлэлгүүд, судалгааны зүүлэлтүүд нь олон талаар ерөнхий зарчим, онолын дүгнэлтүүд дээр үндэслэгдсэн байдаг ба хил хамгаалалтын онолоор хил хамгаалах үйл явцад үүдэх үзэгдлүүд, тэдгээрийн явцыг илүү гүнзгий ойлгож мэдэх боломж олгодог.

Бусад шинжлэх ухааны салбарууд ч гэсэн хил хамгаалалтын онолын танин мэдэхүйн аппарат, судалгаа-шинжилгээний ажлын үр дүнг авч ашигладаг. Тухайлбал, хил хамгаалалтын онолд цэргийн шинжлэх ухаанаар боловсруулагдсан цэргийн урлаг, цэргийн байгуулалт, цэргийн сургалт, хүмүүжил, цэргийн удирдлагын онолын олон зарчмуудыг авч хэрэглэдэг.

Улсын хил хамгаалалтын онолын үндсэн зарчмууд нь:

- Хил хамгаалах байгууллага-Хилийн цэргийг улсын хил хамгаалахад байнга бэлэн байлгах;

¹ М.Ганболд. "Хилийн нэртөмьёоны тайлбар толь". УБ., 2010.

- Байгууллага, цэргийн хүчийг иж бүрэн ашиглах;
- Байгууллага, цэргийн хүчийг харилцан ажиллуулах;
- Хилийн орон зайд улсын хил хамгаалалтыг тасралтгүй явуулах;

Улсын хилийг гүнтэйгээр хамгаалах;
Гол чухал чиглэлүүдэд, хэрэгцээтэй цагт үндсэн хүч хэрэгслийг бий болгох;

Байгууллага, цэргийн хүчийг шилжүүлэн байрлуулахад бэлэн байлгах;

Хил хамгаалалтын идэвхитэй, уян хатан байдлыг хангах;

Байгууллага, цэргийн хүчийг хатуу, тасралтгүй удирдлагаар хангах;

- Байгууллага, цэргийн хүчний бүх төрлийн хангалтыг тасралтгүй хийх;

Ёс суртахуун-сэтгэл зүйн хүчин зүйлүүдийг бүх талаар тооцож ашиглах зэрэг болно¹ хэмээн хил хамгаалах онол, улсын хил хамгаалалтын зарчмын хоорондын учир зүйн холбоос, үндэслэлийг тайлбарлажээ.

Энэхүү судалгааны ажил нь доорх эрх зүйн үндэслэл, зохицуулалтаар улсын хил хамгаалалтын онол, практиктай холбогдож байна.

Монгол улсын хилийн тухай хуульд “Улсын хил хамгаалалтын үндсэн зарчим”

Улсын хил хамгаалалтыг зохион байгуулахад дараах үндсэн зарчмыг баримтлана:

1. Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах
2. Улсын хил дээр зэвсэгт түрэмгийлэл үүсэхээс урьдчилан сэргийлж, хилийн асуудлаар

үүссэн зөрчил, маргааныг энхийн аргаар шийдвэрлэх

3. Улсын хилийг хил залгаа улстай хамтран хамгаалах
4. Улсын хилийг бүсчилэн хамгаалах
5. Хууль дээдлэх
6. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх¹² гэж хуульчлан, эрх зүйн үндсийг хилийн тухай

шинэчилсэн найруулга хуулиар тодорхойложээ.

Монгол Улсын хил хамгаалалтын дүрмийн I дүгээр ангийн дүрэмд: “Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, үндэсний аюулгүй байдлын болоод гадаад бодлогын үзэл баримтлал, төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хилийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж, төр, засгаас хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийг хүндэтгэн сахиж, энэхүү дүрмийг удирдлага болгон хил хамгаалалтыг зохион байгуулж удирдана”, мөн дүрмийн 12 дугаар зүйлд: Хилийн отряд, заставын

¹ Н.Наранцамц. “Улсын хил хамгаалалтын практик асуудлууд”, УБ., 2008, 45 дугаар тал

² Монгол улсын хилийн тухай хууль. УБ., 2016, 32 дугаар зүйл.

хэсэгт улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдахад дараах зарчмуудыг баримтлана.

Үүнд: 1.Хүч хэрэгсэл хилийн дагуу хуваарилагдсан, гүн тийш цуваажсан байх,

2 .Хүч хэрэгсэл болзошгүй ажиллагаанд байнга бэлэн байх,

3 .Үндсэн хүч хэрэгсэл нь хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлд төвлөрсөн байх.

4 .Хил хамгаалалтыг удирдах ажиллагаа идэвхтэй, уян хатан байх,

5.Албаны арга ажиллагаа нууц далд, шуурхай байх.

6 .Хил хамгаалалтын удирдлага бат тууштай, тасралтгүй тогтвортой байх,

7 .Хил хамгаалалтад чиглэсэн бүх ажиллагаа харилцан уялдсан байх,

8.Бүх төрлийн хангалт тасралтгүй байх,

9 .Материал хэрэгслийн зохих нөөцтэй байх¹ гэж тус тус заасан.

Улсын хил хамгаалалтын зарчим, шаардлагын асуудлыг түүхэн талаас нь хил хамгаалалтын дүрэмд туссан байдлыг судлахад 1968 оны хил хамгаалалтын дүрэмд улсын хил хамгаалалтын зарчим, шаардлагыг нэг заалт болгон тусгасан бөгөөд 1970 оны хил хамгаалалтын дүрэмд зарчим, шаардлага нь зарчим болон, 1987 оны хил хамгаалах дүрэмд /Хилийн застав/ улсын хил хамгаалах үндсэн шаардлагууд, 1994 оны хил хамгаалалтын дүрэмд хилийн хорооны хил хамгаалалтад тавигдах шаардлага, 2006 оны хил хамгаалалтын дүрэмд зарчим болон тус тус өөрчлөгдөж, хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрэмд туссан байна.

Дээрх үг зүйн тайлбар, хил судлалын шинжлэх ухааны үндсэн онол болох улсын хил хамгаалалтын урлагын онол, удирдлагын онол, хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрмээр заасан улсын хил хамгаалалтын зарчим, шаардлагуудыг харьцуулан судлахад:

Улсын хил хамгаалалтын зарчим нь ямар нэгэн онол сургаал, шинжлэх ухаан, хууль

дүрэм, хэв заншлын үндсэн зүй ёс, гол баримтлал, мөрдлөг гэсэн үг зүйн тайлбараас дүгнэхэд хилийн тухай хуульд заасан 6 зарчим бол хилийн сратеги бодлогыг тодорхойлсон улсын хил хамгаалалтын бодлогыг боловсруулахад баримтлах зарчим мөн гэж үзэж байна.

Шинээр батлагдсан хилийн тухай хуулиар нэр томъёоны ойлголт, улсын хил хамгаалалтын зарчмын асуудлыг тусгаж өгсөн нь сайшаалтай юм.

Энэ нь доктор, хурандаа Н.Наранжамцын тодорхойлсон Улсын хил хамгаалалтын зарчмуудыг боловсруулах арга зүйгээр батлагдаж байна. Үүнд:

¹ Монгол Улсын хил хамгаалалтын дүрмийн I дүгээр ангийн бүлгийн ерөнхий зүйлийн 7 дугаар зүйл.

Улсын хил хамгаалах үйл ажиллагааны зарчимууд нь амжилт олоход чухал хэрэгцээтэй бүтэц түүний бүрдлүүдийг чанарын үндсэн түвшинг илэрхийлсэн, томоохон олон талт үйл ажиллагааг гүйцэтгэхэд зайлшгүй дагаж мөрдөх баримтлалууд мөн гэж үзээд: Зарчим гэдэг нь улсын хил хамгаалах явцад эсрэг тал (дайсан)-тай тэмцэхэд амжилт олох нөхцлийг бүрдүүлэгч, өөрийн хүч хэрэгслийн өөр хоорондоо нягт холбоо бүхий байнга давтагдаж байдаг, хүмүүсийн оюун санаанд тусгалаа олсон иж бүрэн үйл ажиллагаа гэсэн нь үүгээр батлагдаж байна.

Харин эрдэмтэн, доктор, генерал Ш.Арвай:

Зарчим нь стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд шинжлэх ухаанд үндэслэгдсэн шаардлага нь болдог. Энэ нөхцөлд шаардлага, зарчим хоёр агуулга нь адилаар шинжийг хадгалдаг.

Дэлхийн хамтын нийгэмлэгийн хэмжээнд хилийн талаар баримтлах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг үндсэн удирдлага болгож байна. Үүнд:

1. Дэлхийн “геостратег”, бүс нутгийн хэмжээнд дэх олон улсын байдлыг харгалзан үзэх зарчим;

Монгол улсын хил нь олон улсын хилийн нэгэн хэсэг бөгөөд НҮБ-ын гишүүн улсын хувьд улсын хил “нээлттэй”, “хаалттай” байх шаардлагыг зөв хослуулах нь онцгой ач холбогдолтой болж байна. Монгол улсын хил нь тус улсын бүрэн эрх, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдлыг хангаж, үндэсний язгуур эрх ашгийг хамгаалах үүднээс, мөн олон улсын терроризм, гэмт явдлаас найдвартай хамгаалагдсан байх буюу “хаалттай” гэдэг үгийг энд хамааруулж байна. Харин олон улсын болон Монгол улсын зорчигчид бараа таваарыг улсын хилээр нэвтрүүлэх, ялангуяа зорчигчдын эрх эрх чөлөөг хангаж үйлчлэх талаар олон улсын нийтлэг зарчмыг хатуу баримталж, мөрдөх учиртай. Энэ нь хил “нээлттэй” байх гэсэн агуулгыг илэрхийлж байгаа юм. Энэ нь улс төр, нийгмийн төдийгүй эдийн засгийн ач холбогдолтойг бас харгалзан үзэх эрэлт хэрэгцээнд нийцдэг.

2. Улсын хил дээр, хил орчмын нутаг улс болон орон нутгийн язгуур эрх ашигт учирч байгаа аюул, заналд улсууд адил тэнцвэртэй байдлаар хандах зарчим;

Энэ нь НҮБ-ын дүрмээр хүлээсэн үүрэг, “хоёр улс-нэг хил” гэж хандах үзэл байдалтай нэн тэргүүнд холбогддог.

3. Сайн хөршийн ёсоор хилийн харилцааг хүндэтгэн үзэх зарчим.

Монгол улс нь ОХУ, БНХАУ-тай улсын хилийг баталгаатай болгож улсын хилийн дэглэмийн тухай олон улсын шинжтэй гэрээнүүдийг байгуулж, хэрэгжүүлж байгаа юм. Хөршлөх улсууд тогтоогдсон хилд нэн хүндэтгэлтэй хандах, улсын хилийн дэглэм бусад харилцааны талаар байгуулсан гэрээ, хэлэлцээр хангагдах нөхцөл бүрдүүлхийн төлөө манай хоёр хөрш идэвхтэй бодлого, үйл ажиллагаа явуулж байна.

Монгол улсын одоогийн тогтоосон хил нь 37-51 жилийн өмнө бүрэн баталгаажсан боловч харьцангуй шинэлэг шинж агууллагатай учраас тухайн хилийн баталгаажилт, хамгаалалтын бодит нөхцөл байдлыг хангах талаар Төрөөс онцгой анхаарч шаардлагатай арга хэмжээнүүдийн улс орны хэмжээнд өрнүүлэн хэрэгжүүлж байна.

Энэ бүх Улсын хил дээр гарсан асуудлыг энхийн аргаар шийдвэрлэх цаашид хил хязгаарт аль аль нь талдаа үл ойлголцох, хилийн зөрчил будлиан үүсэхээс урьдчлан сэргийлсэн бодлого, үйл ажиллагааны эрх ашиг шаардлагад нийцэж байна. Монгол улс, ОХУ, БНХАУ-нь улсын хилийг найрамдал гэдгээр халхавчилж, хил манах, хамгаалах бодлого, үйл ажиллагааг сулруулах бус харин хилийн багана тэмдэг байх ёстой газар дээрээ бат бэхээр оршиж, улсын хил өөрчлөгдөхгүй, зөрчигдөхгүй байх эрх ашигт нийцүүлэн хил манах, хамгаалах нөхцөл бүрдүүлэхэд адил хэмжээнд сайн хөршийн ёс журмыг сахих хүрээ хязгаарт багтаан бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Цаашид аль нэг нь нөгөөгөөсөө ялангуяа цэргийн хувьд давуу байх нь ашиг өгөхөөс, хор холбогдол илүүтэй гэдэг байр сууринаас хандах нь зүй ёсны анхаарах асуудлын нэг мөн.

4. Стратегийн зорилго нь боломжтойгоо нийцэж байх зарчим;

Монгол улсын хил, хягаарын аюулгүй байдлыг хангах зорилгод түүний нөхцлийг хангах улсын боломж нийцэж байх нь онцгой ач холбогдолтой. Зориго, боломж хоёрын хооронд зөрөө гарвал улсын хилийн баталгаажилт, хамгаалалтын чанарт сөрөг нөлөөлж, улсыг хилийн багана, тэмдэг хяналтын гадна үлдэж эвдэрч, үгүй болох, хилийг хууль бусаар зөрчих, тэр нь даамжирч хилийн будлиан, халдлага, түрэмгийлэл үүсэх шалтаг болж хувирдаг аюултай. Иймд энд дурдсан энэ зарчмыг хэрэгжүүлэхэд урлаг онцгой байр эзэлдэг. Өөрөөр хэлбэл зөрчил, халдлага түрэмгийлэлээс урьдчилан сэргийлж, хил хягаарын найдвартай, бат бэх байдлыг хангах явдал юм. Энэ хүрээнд бидэнд сөргөөсөө зэрэг үзэгдэл, туршлага хангалтай бий. Стратегийн түвшинд ганцхан жишээг авч үзвэл манай өвөг, дээдэс өмнөдийн боломжийг ашиглан умард хилээ тогтоож, умардын боломжид тулгуурлан өмнөд хилээ тогтоож авсаныг би жишээ болгон тэмдгэлсэн.

5. Хил хязгаарын нутаг дэвсгэрт оршин суугчдад хүндэтгэлтэй хандах зарчим;

Хил хязгаарын нутаг дэвсгэрт оршин амьдарч байгаа Монголын иргэн мөн ОХУ, БНХАУ-аас манай улсын хилтэй хаяалан суурьшиж байгаа хөрш улсын иргэдийн эрх, чөлөө, ёс заншилд хүндэтгэлтэй хандах зарчим нь хөрш улс орнууд тэдгээрийн ард иргэдэд ч хамааралтай онцгой ач холбогдолтой чухал асуудал. Энд Монгол улсын гадна талд түүхэн нөхцөл байдлаас шалтгаалан ихэнх төлөв монгол үндэстэн, ястан оршин суудаг онцлог бий. Өөрөөр хэлбэл энд монголын яс махны тасархай, түүхэн уламжлалд заншил, шашин шүтлэг маш олон зүйлээр амин холбоотой байдаг ард иргэд оршин амьдардаг

онцлогтой. Эндээс үүдэн хүний эрхийн түгээмэл тунхаглалын дагуу. хилийн хоёр талд оршин суугаа иргэн өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор хүндэтгэлтэй хандах нөхцөл бололцоог бүрдүүлж, хадгалж, хөгжүүлэх нь стратегийн нэг чухал зорилт болон дэвшигддэг. Нөгөө талаар НҮБ-ын дүрэмд зааснаар аливаа ард түмэн улс төрийн эрх чөлөөгөө өөрийн дураар сонгож. аль нэг улс гүрний, бүрэлдэхүүнд эс бол бие даан оршин амьдрах эрхтэй юм. Монголын ард түмэн Үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн иргэдийнхээ дархан эрх, эрх чөлөөг эдлэхийн зэрэгцээ хилийн гадна оршин суугаа ОХУ, БНХАУ-ын тухайн улсын үндсэн хуулиар эрх нь баталгаажсан иргэн бүхэнд хүндэтгэлтэй хандах учиртай.

Харин манай улсын хилийн бодлогын стратег бол монголчуудыг Монгол улсын эсрэг хандсан бодлого үйл ажиллагааны арга, хэрэгсэл болгож ашиглаж байсан бурангуй ёсыг үгүй болгож, хил орчим оршин суугчдыг терроризм, хэт үндэсрхэг үзэл баримтлагчид, хил дамнасан хүний наймаа, хар тамхи, байгалийн болон үйлдвэрийн баялгийг хууль бусаар зувшуулагчдын гар хөл болох гэмт явдлаас сэргийлж, тэдний үйлдэлийг таслан зогсоож, улсын хил, хязгаар нутагт улс, нийгэм иргэдийн эрх ашгийг тууштай хамгаалахад чиглэгдэж байх ёстой.

6. Олон хувилбартай байх зарчим;

Хувирч өөрчлөгдөх юмс үзэгдэл, үйлдэл энэ ертөнцөд байдаггүй. Бүх юм учир шалтгаантай. Эерэг тал нь зөвөөр нөлөөлбөл хөгжил урагшилна. сөрөг тал нь давуутай нөлөөлбөл хөгжил зогсонги байдалд орж, зарим тохиолдолд ухрах үзэгдэл ч гардаг. Энэ лугаа хил хязгаарын нөхцөл байдал, ихэнх төлөв цэрэг улс төрийн шалтаг, шалтгаанаас үүдэн хувирч өөрчлөгдөж байдаг зүй тогтол ажиглагддаг. Түүний дагаад төрийн хилийн бодлого тодорхой цаг хугацаа, нөхцөл байдлаас үүдэн шинжлэгдэн өөрчлөгдөж, тодотгогдож байдаг юм. Монгол улсын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах ерөнхий стратегээс гадна аюул, занал учруулж болзошгүй тодорхой чиглэлд улс нийгмийн эрх ашгийг хангах, ойрын зайнд мөрдөгдөх онцгой маягийн хувилбар бүхий хэд хэдэн орон нутгийн шинж агууллагатай стратеги байх шаардлагатай гэсэн дүгнэлтэн хүргэж байна.

7. Харилцан тусалцаж, түншийн холбоотой ажиллах зарчим;

Төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэх стратегд энэ зарчим дэлхий, бүс нутаг. хөрш улсууд тэр дотроос тухайн улсын дотоод онцгой ач холбогдолтойг практик харуулж байна. Энд нөлөөлж байгаа гол хүчин зүйлүүдэд, дэлхийн хувь заяг шийдвэрлэхэд тодорхой байр эзэлж үүрэг хүлээдэг НҮБ-ын өсөн нэмэгдэж байгаа нэр хүнд. үүрэг роль, улс бүрэн хилтэй байдаг зүй тогтол, тэр нь олон улсын шинж чанар хадгалдаг онцлог, хилийн аюулгүй байдлыг хангахад нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, терник, соёл, боловсрол, мэдээлэл, зэрэг чиглэл, салбаруудыг ерөнхийд нь нэгдмэл нэгэн орон зайнд багтаан ашиглах дэлхийн хамтын нийгэмлэгийн эрх ашиг сонирхол багтаж байна. Өөрөөр хэлбэл Монгол улсын олон улсын чанартай хилийг НҮБ-ын

зохих байгууллагаар батлагдаж, хүлээн зөвшөөрсөн хэмжээнд найдвартайгаар баталгаатай хамгаалахын тулд дэлхийн хамтын нийгэмлэгийн улс бүрэнтэй түншийн харилцаа тогтоож, харилцан тусалж, хамтран ажиллах бололцоо бий болов. Төрийн хилийн бодлогыг хэрэгжүүлэх стратегийг бололвсруулж, хэрэгжүүлэхэд эдгээр зарчмуудыг туйлын бүтээлчээр тусгаж ашиглах шаардлага гарч байна. Улс ард түмэн өөрийн эзэмшлийн орон зайн хил хязгаарыг хамгаалах бодлого баримталж, хэрэгжилтийг стратегийн арга зүй албаны онцлогийг хослуулан хэрэгжүүлж ирсэн байна. Орчин үеийн түвшинд Төрөөс хилийн бодлогын стратег гэсэн ойлголтын тодорхой ай савыг бий болгожээ.

Хилийн бодлогын стратегийн үүсэл хөгжил, стратегийн тухай ойлголт, стратегийн зорилго, зорилтууд, зарчмуудыг хураангуйлсан байдлаар авч үзэв.¹

Эндээс үзэхэд дээрх 2 эрдэмтний стратегийн түвшинд тодорхойлсон улсын хил хамгаалалтын зарчим, шаардлагуудын тодорхойлолт, ойлголт нь ижил санаа агуулж байна.

Харин улсын хил хамгаалалтын шаардлага нь шавдаж шаардах үйлийн нэр; *шаардлага сайтай;

шаардлага муутай; ажлын шаардлага; хэрэгцээний шаардлага; өнөөгийн шаардлага; цаг үеийн шаардлага; эдийн засгийн шаардлага, үйл ажлыг гүйцэтгэх бүтээхэд зайлшгүй холбогдох нөхцөл бололцоог нээх, шаардлага тавих; шавдах шаардах, нэхэх шаардах хэмээх үг үйн тайлбараас харахад улсын хил хамгаалалт буюу хилийн тухай хуульд тодорхойлсон 7 төрлийн үйл ажиллагааны нэр үг буюу зайлшгүй хийгдэх үйл ажиллагааны үнэлгээ, шалгуур үзүүлэлт гэсэн утгыг илэрхийлж байна.

Улсын хил хамгаалалтад тавигдах шаардлагын талаар одоогоор хилийн тухай хууль, дүрэмд тусгагдаагүй боловч хил хамгаалалтын нэгдүгээр ангид заасан 9 төрлийн зарчим нь ХХЕГ-ын даргын улсын хил хамгаалалтыг удирдан зохион байгуулах удирдамжинд тусгагдан, ангийн захирагчийн тушаал, заставын даргын хоногийн хил хамгаалах төлөвлөгөөгөөр дамжин оператив, тактикийн түвшинд улсын хил хамгаалалтын албаны үйл ажиллагааны шаардлага болон хэрэгжиж байна гэж ойлгогдож байна.

Улсын хил хамгаалалтын шаардлагын талаар эрдэмтэн, доктор, генерал Ш.Арвай: Хил хамгаалах байгууллага нь Төрийн хилийн бодлогыг байгууллалын хүрээнд хэрэгжүүлхийн тулд тодорхой шаардлагуудыг баримтлах хэрэгтэй болдог. Үүнд:

- Хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүний тоо нь хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтуудыг хангах бололцоотой нийцэж байх;

Ш.Арвай. "Монгол улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог", 2015., 103 дугаар тал.

- Хил хамгаалах байгууллагын бүрдүүлсэн мэргэжлийн хүч хэрэгсэл, бүтэц, бүрэлдэхүүн нь цагийн байдал яаж ч өөрчлөгдсөн янз бүрийн зориулалттай бүтэц бүхий бүлэг нэгж бүрдүүлэх хүрэлцээг хангаж байх(хүч хэрэгслийн тогтолцоо);
Улсын хил хамгаалах үүрэг хүлээсэн субъектүүдийн хангалт, үйлчилгээ нь тухайн цаг үед шийдвэрлэхээр дэвшүүлсэн зорилго, зорилтуудтай нийцэж тохирсон, хүчний харилцаа ойролцоо байх;
- Хил хамгаалах байгууллагаас бүс нутгийн хэмжээнд байгуулагдсан бүлэглэл /анги, салбарууд/ цагийн байдал гэнэт өөрчлөгдсөн нөхцөлд онцын нэмэгдэл арга хэмжээ авалгүйгээр алба-байлдааны үүрэг гүйцэтгэх чадвартай байх;
- Удирдлагын тогтолцоо нь байгуулагдсан бүлэглэлийг ердийн нөхцөлд тогтвортой удирдахаас гадна цагийн байдал хурцадсан үед чадварлаг ажиллах бололцоог дэс дараа, үе шаттай бүрдүүлэх чадвартай байх;¹ хэмээн оновчтой тодорхойлжээ.

Дээрх нөхцөл байдлуудаас нэгтгэн дүгнэхэд улсын хил хамгаалалтын зарчим нь стратеги, оперативын түвшинд хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрэмд тусгагдан хэрэгжиж бата.

Харин улсын хил хамгаалалтын шаардлага нь улсын хил хамгаалалтыг газар орон дээр удирдан, гүйцэтгэж буй хилийн анги, застав, харуульш буюу оператив, тактикийн түвшинд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах удирдамжид тусгагдсан зарчмуудын дагуу шууд үйл ажиллагаа болон хэрэгжиж байна.

Эндээс улсын хил хамгаалалтын шаардлага нь улсын хил хамгаалалтын зарчмын дагуу зайлшгүй хийгдэж, мөрдөх шалгуур үзүүлэлт, хийх ёстой үйлийн нэр үг гэсэн утга, онол, арга зүйн учир холбоос болж байна гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл улсын хил хамгаалалтын зарчим бол төрийн хилийн бодлого бөгөөд энэ нь хууль, МУ-ын олон улсын гэрээ, хэлэлцээгээр зохицуулагддаг, харин улсын хил хамгаалалтын шаардлага нь улсын хил хамгаалалтын үйл ажиллагааны хэлбэр, арга зүй болон оператив, тактикийн түвшинд хил хамгаалалтын зарчмын шууд тусгал болон дүрэм, тушаал, захирамжаар зохицуулагдана гэж ойлгож болох юм.

ЕРӨНХИЙ Д ҮГНЭЛТ

“Улсын хил хамгаалалтад тавигдах шаардлага, түүний хэрэгжилтийг судласан нь” сэдвийн онол арга зүйн үндэслэлийг **нэгдүгээрт**: хил судлалын

¹ Ш.Арвай. “Монгол улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог”, 2015., 113 дугаар тал.

шинжлэх ухааны ойлголт, улсын хил хамгаалалт хэмээх тодорхойлолт, зарчим, шаардлагын тухай хэл зүйн тайлбар, ойлголтыг судлах. **хоёрдугаарт:** улсын хил хамгаалалтын зарчим, шаардлагуудын онолын болон эрх зүйн ойлголтууд, хил судлалын шинжлэх ухааны удирдлагын онол, хил хамгаалах урлагын онол, түүнчлэн хилийн аюулгүй байдалтай хэрхэн холбогдох онолын үндэслэл, хоорондын харилцан хамаарал, учир зүйн холбоосыг гаргаж өгөх нь зайлшгүй юм гэж үзэн түүхэн хөгжил, эрх зүйн үндэслэлтэй холбон судаллаа.

Улсын хил хамгаалалтын зарчим, шаардлагын асуудлыг түүхэн талаас нь хил хамгаалалтын дүрэмд туссан байдлыг судлахад 1968 оны хил хамгаалалтын дүрэмд улсын хил хамгаалалтын зарчим, шаардлагыг нэг заалт болгон тусгасан бөгөөд 1970 оны хил хамгаалалтын дүрэмд зарчим, шаардлага нь зарчим болон, 1987 оны хил хамгаалах дүрэмд /Хилийн застав/ улсын хил хамгаалах үндсэн шаардлагууд, 1994 оны хил хамгаалалтын дүрэмд хилийн хорооны хил хамгаалалтад тавигдах шаардлага, 2006 оны хил хамгаалалтын дүрэмд зарчим болон тус тус өөрчлөгдөж, хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрэмд туссан байна. /Судалгаа-1/

Дээрх үг зүйн тайлбар, хил судлалын шинжлэх ухааны үндсэн онол болох улсын хил хамгаалалтын урлагын онол, удирдлагын онол, хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрмээр заасан улсын хил хамгаалалтын зарчим, шаардлагуудыг харьцуулан судлахад:

Улсын хил хамгаалалтын зарчим нь ямар нэгэн онол сургаал, шинжлэх ухаан, хууль дүрэм, хэв заншлын үндсэн зүй ёс, гол баримтлал, мөрдлөг гэсэн үг зүйн тайлбараас дүгнэхэд хилийн тухай хуульд заасан 6 зарчим бол хилийн стратеги бодлогыг тодорхойлсон улсын хил хамгаалалтын зарчим мөн гэж үзэж байна.

Улсын хил хамгаалалтад тавигдах шаардлагын талаар одоогоор хилийн тухай хууль, дүрэмд тусгагдаагүй боловч хил хамгаалалтын нэгдүгээр ангид заасан 9 төрлийн зарчим нь ХХЕГ-ын даргын улсын хил хамгаалалтыг удирдан зохион байгуулах удирдамжинд тусгагдан, ангийн захирагчийн тушаал, заставын даргын хоногийн хил хамгаалах төлөвлөгөөгөөр дамжин оператив, тактикийн түвшинд улсын хил хамгаалалтын албаны үйл ажиллагааны шаардлага болон хэрэгжиж байна гэж ойлгогдож байна.

Хөрш орон БНХАУ-ын хил хамгаалалтын зарчим, шаардлагуудыг судлахад БНХАУ хил хамгаалалтдаа 9 зарчим баримталдаг бөгөөд зарчим бүр нь зайлшгүй хийгдэх 2-5 үйл ажиллагаа буюу шаардлага болон задарсан, түүнийгээ бодлогын баримт бичиг болгон албажуулж, ямар ч төрийн тогтолцооны үед удирдлага өөрчлөгдсөн ч гэсэн хэрэгжүүлж чадаж байна гэж дүгнэж байна. Энэ нь эрдэмтэн доктор, генерал Ш.Арвайн дэвшүүлсэн санаатай нийцэж байна.

Харин ОХУ-ын хил хамгаалалтад баримталж буй зарчим нь эрдэмтэн, доктор, хурандаа Н.Наранжамцын судалгаа болон одоо мөрдөгдөж буй хил хамгаалалтын дүрэмд заасан зарчимуудтай ойролцоо утгыг илэрхийлж байна.

Дээрх нөхцөл байдлуудаас нэгтгэн дүгнэхэд улсын хил хамгаалалтын зарчим нь стратегийн түвшинд хилийн тухай хууль, хилийн талаар байгуулсан МУ-ын олон улсын гэрээ, хэлэлцээрт тусгагдан хэрэгжиж байна.

Харин улсын хил хамгаалалтын шаардлага нь улсын хил хамгаалалтыг газар орон дээр удирдан, гүйцэтгэж буй хилийн анги, застав, харуулын буюу оператив, тактикийн түвшинд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах удирдамжид тусгагдсан зарчмуудын дагуу шууд үйл ажиллагаа болон хэрэгжиж байна.

Иймд хил хамгаалах байгууллага хилийн тухай хуульд заасан улсын хил хил хамгаалалтын зарчим бүрт тохирсон шаардлагуудыг хил хамгаалалтын 3, 2 дугаар ангийн дүрэмд, улсын хил хамгаалалтын зарчмыг одоо байгаа хил хамгаалалтын 1 дүгээр ангийн дүрмийн заалтыг шинэчлэн, 2, 1 дүгээр ангийн дүрэмд тус тус тусгайлан зааж, хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэж байна.

Хилч эрдэмтэн, доктор, генерал Ш.Арвайн дэвшүүлсэн стратегийн зарчим, шаардлагын талаарх онолын санаа нь стратегийн түвшинд буюу илүү өргөн утгыг илэрхийлж, одоогийн мөрдөгдөж байгаа хилийн тухай хуулийн 6 зарчимтай ижил утгатай байгаа бол харин хилч эрдэмтэн, доктор, хурандаа Н.Наранжамц хурандаагийн тайлбарласан онол нь одоо мөрдөгдөж буй хил хамгаалалтын нэгдүгээр ангийн дүрмийн улсын хил хамгаалалтад тавигдах 9 зарчимтай ижил утгатай байна.

Эндээс одоогийн хил хамгаалалтын дүрэмд тусгагдсан зарчим нь хуучин дүрмүүдэд шаардлага гэж тайлбарлагдаж байгаад сүүлийн дүрмээр зарчим болон хувирсан, мөн эдгээр зарчмын заалтууд нь оператив, тактикийн түвшинд зайлшгүй хэрэгжих улсын хил хамгаалалтын шаардлага буюу үйл ажиллагаа болон хэрэгжиж байна гэсэн учир зүйн дүгнэлтэд хүрч байна.

Судалгаа-2-оос улсын хил хамгаалалтад тавигдаж буй 9 зарчмууд хилийн отрядын даргын улсын хил хамгаалалтыг зохион байгуулах тушаал, заставын даргын улсын хил хамгаалах хоногийн төлөвлөгөөнд шууд хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу улсын хил хамгаалалтад тавигдах шаардлага болон тусгагдан, хэрэгжиж байгаа нь батлагдаж байна.

Судалгаа-3-аас ХХЕГ-ын ажил дүгнэх журамд улсын хил хамгаалалтын дүрэмд заагдсан улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдахад тавигдах зарчмын заалтууд тусгагдаагүй, харин үйл ажиллагааг чиглэл тус бүрээр дүгнэх шалгуур үзүүлэлтүүд буюу зайлшгүй хийгдэх үйл ажиллагаа.

улсын хил хамгаалалтад тавигдах шаардлагууд тусгагдсан байна гэж харагдаж байна.

Гэхдээ өнөөгийн байдлаар улсын хил хамгаалалтад тавигдах шаардлага гэсэн тодорхойлолт хилчний тайлбар тольд байгаагаас өөр ямар ч хууль, эрх зүйн баримт бичигт энэ талаар огт тусгаагаагүйг харгалзан үзэхэд энэ нь ч зөв юм.

Иймд хил хамгаалалтын дүрэм, ХХЕГ-ын ажил дүгнэх журамд улсын хил хамгаалалтад тавигдах шаардлагуудыг нарийвчлан задлаж оруулж өгөх нь чухал юм.

Эцэст нь бодлогыг хэрэгжүүлэх стратег нь зарчмаар хэрэгждэг бол зайлшгүй хийгдэх үйл ажиллагаа, арга зүй нь шаардлага юм гэж дүгнэж байна. Эндээс:

- *Зарчим-Бодлого*
- *Шаардлага-Үйл ажиллагаа. арга зүй-* гэж тодорхойлж байна.

***Судалгааны явцад хийсэн дүгнэлтийг үндэслэн
дараах саналуудыг дэвшүүлж байна:***

1 .Улсын хил хамгаалалтын зарчим, шаардлагуудыг хөрш орнуудын хилийн стратеги, бодлогод тавьж буй зарчим, шаардлагуудтай уялдуулан, төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хилийн тухай хуульд заасан улсын хил хамгаалалтад тавигдах зарчмуудыг хэрэгжүүлэх шаардлагуудыг зарчим тус бүр дээр тодорхойлон, хил хамгаалалтын дүрмээр баталгаажуулах.

2 .Монгол улсын хилийн тухай хуульд заасан улсын хил хамгаалалтын зарчим, хилч эрдэмтэн, доктор, генерал Ш.Арвайн боловсруулсан хил хамгаалалтын стратегийн зарчмуудыг нэгтгэн, одоогийн хил хамгаалалтын нэгдүгээр ангийн улсын хил хамгаалалтын зарчмын заалтуудыг өөрчлөн найруулах, хил хамгаалалтын нэг, хоёрдугаар ангийн дүрэмд тусгах.

3 .Одоогийн мөрдөгдөж буй улсын хил хамгаалалтын зарчмуудыг хэрэгжүүлэх шаардлагуудыг зарчим бүрээр дахин боловсруулж, улсын хил хамгаалалтад тавигдах шаардлагуудыг хил хамгаалалтын хоёр, гуравдугаар ангийн дүрэмд тусган, хэрэгжүүлэх.

4 .Улсын хил хамгаалалтын зарчим, шаардлага хэмээх ойлголтыг ялгавартайгаар ойлгон, хил судлалын шинжлэх ухааны категори болгон онолын хувьд баталгаажуулан, нэгдсэн ойлголттой болгох.

5 .Улсын хил хамгаалалтын зарчим, шаардлагын асуудлыг цаашид онолын түвшинд нарийвчлан судлах асуудлыг хилч эрдэмтдийн дунд өрнүүлэх.

6 .ХХЕГ-ын ажил дүгнэх журамд улсын хил хамгаалалтад тавигдах шаардлагуудыг нарийвчлан оруулж өгөх